# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ДАЛАЙБААТАРЫН БАТ-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг: Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Гүйцэтгэлийн хувь |
| Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах | | | | | | | |
| 1 | Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, хувиар | - Цахимаар өөрөө мэдүүлэх мэдүүлгийн тоог нэмэгдүүлэх чиглэлд гадаад худалдаа эрхлэгчдэд Gaali.mn системийг сурталчилж ажилласан.<br>- 2023 он гарсаар 3636 гаалийн бүрдүүлэлтийг тухайн аж ахуйн нэгж өөрсдөө мэдүүлсэн байгаа нь өмнөх онд 198 гаалийн мэдүүлгийг өөрөө мэдүүлж байснаас 18 дахин өссөн үзүүлэлттэй байна. | 1. Бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааг бууруулах, зорилгоор тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.<br>2. Гадаад худалдаа эрхлэгч нарт гаалийн хууль тогтоомжийг сурталчлан, мэдээлэл өгч ажиллана.<br>3. Аж ахуйн нэгж өөрөө мэдүүлэх боломжийг бүрдүүлэн, өөрөө мэдүүлсэн бүрдүүлэлтийн тоо өнгөрсөн оноос 5 хувь буюу түүнээс дээш нэмэгдсэн байна.<br>4. Гадаад худалдаанд оролцогч иргэд, ААН-ийн хууль сахилтын түвшин болон бусад үзүүлэлтээр эрсдийн төрөлжсөн судалгааг хийж, ГЕГ-ын нэгжид танилцуулан гаалийн хяналт, шалгалтын | 1. Тус газрын гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилтийг хийх зорилгоор 2024.11.05-06-ны өдрүүдэд ГЕГ-ын сургалтанд сууж чиглэл авсны дүнд 11-р сарын үзүүлэлтэд уг хэмжилт судалгааг хийх шаардлага бий болсон бөгөөд энэ судалгааг 12-р сардаа багтаан хийэ дуусган үнэлэлт, дүгнэлт өгч ГЕГ-т хүргүүлэх ажлын бэлтгэлийн хангаж байна. 2. Тус газрын томоохон аж ахуйн нэгж болох Петродайчин тамсаг ХХК, Шинь Шинь ХХК, Меланж ХХК нарын холбогдох албанй хүмүүст Эдийн засгийн итгэижлэгдсэн оператор болсны давуу тал, ач холбогдол, түүнд тавигдах шаардлагын талаар сургалтыг зохион байгуулсан бөгөөд ялангуяа Шинь Шинь ХХК-ны байранд очиж Дотоод хяналт, архив бичиг баримтын хадгалалтын үйл ажилагаатай ажлын байранд очиж танилцаж зөвлөгөө чиглэл өгч ажиллаа. Мөн улсын хилээр нэвтэрч буй зорчигч, байгууллагад гаалийн холбогдолтой хууль дүрэм журмын тараах материал бэлдэх, дэлгэцээр мэдээлэх, 2024 оны 06-р сард "Нээлттэй хаалганы" өдөрлөг зохион байгуулж ажилласан болно. Ялангуяа эрсдэл бүхий Хүнсний ногоо, өндөг, пиво, тамхи, хүн малын эм, хуурамч архины мэдээллийг гарч буй | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйл ажиллагаанд ашигласан байна. | зорчигч бүрт тухайлан санамж, мэдээлэл өгч ажилласны дунд Хүнсний ногоо холбогдох дүрэм журмын дагуу гаалийн бүрдүүлэлт хийдэг болсон, хуурамч архитай холбоотой 12, тамхитай холбоотой 14, хүн малын эм 31 зөрчил илрүүлсэн байна. | | |
| 2 | Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | Гаалийн хяналтын төлөвийн дүн шинжилгээг хийж, экспорт, импортын бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд ажилласан. Хяналтын төлөв өөрчлөлт баталгаажихаас өмнө 781 баталгаажсаны дараа 283 хийгдсэн. Нийт бүрдүүлэлтийн 7.53 хувь нь засварт буцаагдсан байна. Шалгалтын үр дүнгийн саналд дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлагнаж ажилласан. | 1. Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр гарсан саналыг ГЕГ-т хүргүүлсэн байна<br>2. Хяналтын төлөв солилт, шалгалтын үр дүнгийн "Саналгүй" саналыг 5 хувиар бууруулсан байна.<br>3. Хууль сахилтын түвшин өндөртэй ААН-ийн судалгааг хийж гаалийн хяналт шалгалтаас чөлөөлүүлэх талаар саналаа ГЕГ-ын эрсдлийн удирдлагын нэгжид хүргүүлсэн байна. | 1. Тус газарт 2022, 2023, 2024 оны эхний улиралд гаалийн бүрдүүлэлт хийсэн аж ахуйн нэгж, иргэн бүрийн судалгааг нэгтгэн гаргаж гадаад худалдаа эрхлэгч тус бүрт нь эрсдэл тооцон холбогдох журмын дагуу эрсдлийн үнэлэлт, дүгнэлт өгсөн Төрөлжсөн дэлгэрэнгүй судалгааг хийж 2024.03.28-ны өдрийн 01/154 тоот албан бичгээр ГЕГ-ын Эрсдлийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн болно. 3. Мөн уг төрөлжсөн судалгааны дагуу эрсдлийн түвшинг шинэчлэх Хууль сахилтын түвшин өндөр аж ахуйн нэгжүүдийн биет шалгалтаас чөлөөлөх хувийг нэмэгдүүлэх, эрсдэл өндөр бараа, аж ахуйн нэгжийн шалгуурыг нэмэгдүүлэх саналыг судалгаа хамт гарган 2024.06.06-ны өдрийн 01/253 тоот албан бичгээр хүргүүлэн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна. Дээрх ажлуудыг зохион байгуулсны дунд 2024 онд биет шалгалтаас чөлөөлөгдсөн гаалийн бүрдүүлэлтийн тоо 13309 буюу 75.61% болсон өмнөх оны гүйцэтгэлээс 3,78%-иар өссөн сайн үзүүлэлттэй байна. Хэрэд МЗХ-аар шийдвэр гарсан бол энэ үзүүлэлт нэлээд хэдэн хувиар өсөх төлөвтэй байсан болно | 2024.01.01-2024.12.31 | |
| 3 | Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 оны эхний 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт гаалийн бүрдүүлэлтийн бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 64% байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй | 1. Тус газрын гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээ, төрөлжсөн судалгаа хийж ГЕГ-ын эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжид хүргүүлэн шийдвэр гаргуулсны дүнд нийт | 1. Тус газарт 2022, 2023, 2024 оны эхний улиралд гаалийн бүрдүүлэлт хийсэн аж ахуйн нэгж, иргэн бүрийн судалгааг нэгтгэн гаргаж гадаад худалдаа эрхлэгч тус бүрт нь эрсдэл тооцон холбогдох журмын дагуу эрсдлийн үнэлэлт, дүгнэлт өгсөн Төрөлжсөн дэлгэрэнгүй судалгааг хийж 2024.03.28-ны өдрийн 01/154 тоот албан бичгээр ГЕГ-ын Эрэдслийн | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулсан арга хэмжээ | | харьцуулахад 15 хувиар өссөн үзүүлэлттэй. Бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээ импортын гаалийн бүрдүүлэлтэд 24%, экспортын гаалийн бүрдүүлэлтэд 84% хийгдсэн байна.<br> “Эрсдэлийн удирдлагын программ”-д оруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулах чиглэлийг хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд 2023 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 55 хяналтын хуудсаар 593 шалгуурыг программд оруулсан. | гаалийн бүрдүүлэлтийн тоонд эзлэх биет шалгалтаас чөлөөлөгдөх гаалийн бүрдүүлэлтийн хувийг суурь түвшингөөс 5 нэгжээр нэмэгдүүлсэн байна.<br>2. Тодорхой эрсдэл бүхий барааг онилж, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч, ажил зохион байгуулсан байна. (ЭУСГХС 2.3 дахь хэсэг)<br>3. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг сайжруулах чиглэлээр сургалт, уулзалт, сурталчилгаа хийсэн байна. | удирдлагын хэлтэст хүргүүлсэн болно. Мөн уг төрөлжсөн судалгааны дагуу эрсдлийн түвшинг шинэчлэх шаардлагатай аж ахуйн нэгж, иргэдийн Бүрэн судалгааг хийж 2024.06.06-ны өдрийн 01/253 тоот албан бичгээр хүргүүлэн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна. Дээрх ажлуудыг зохион байгуулсны дүнд 2024 онд биет шалгалтаас чөлөөлөгдсөн гаалийн бүрдүүлэлтийн тоо 13309 буюу 75.61% болсон өмнөх оны гүйцэтгэлээс 3,78%-иар өссөн сайн үзүүлэлттэй байна. Хэрэд МЗХ-аар шийдвэр гарсан бол энэ үзүүлэлт нэлээд хэдэн хувиар өсөх төлөвтэй байсан болно.<br>2. Дорнод аймаг дахь гаалийн газрын харьяа хилийн боомтуудаар бүх нийтийн баярын өдрүүдтэй холбоотойгоор улсын хилээр гарал үүсэл тодорхойгүй, оюуны өмчийн зөрчилтэй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хуурамч архи болон БНХАУ-ын пиво орж ирэх эсдэл байгааг Хяналт шалгат, Хорио цээр, Зөрчил хариуцсан ГУБ нарт анхааруулга санамж өгөх, улсын хилээр нэвтэрч буй зорчигч нарт анхааруулга, санамж бэлдэн тараах, зөрчил гарсан ториолдолд холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэх анхааруулж ажиллаа. Мөн Хүнсний тухай хууль болон холбогдох хорио цээрийн хяналтын хууль журамд заасан хүнс тээвэрлэх тусгай зорилалт бүхий автомашинд экспортын Эрүүл ахуйн гэрчилгээгүй хүний эрүүл мэндэд хор уршиг хүргэж болзошгүй өндөг, хүнсний ногоо зэргийг шаардлага хангуулан улсын хилээр нэвтрүүлж гаалийн бүрдүүлэлт хийх талаар холбогдох ГУБ болон аж ахуйн нэгж, иргэдэд анхааруулга санамж өгч түүнд хяналт тавьж ажиласаны дүнд уг эрсдлийг арилгаж чадсан болно.<br>3. Газрын Хяналт шалгат, Хорио цээр, Зөрчил хариуцсан ГУБ нарт Эрсдлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлагад суурилсан хяналтыг хэрхэн хийх, төлөв өөрчлөх шалтгаан, нөхцөл болон гаалийн бүрдүүлэлт хийж буй үед эрсдлийн мэдээллийг хэрхэн оруулах, түүнийг ашиглах талаар сургалтыг 2 удаа онлайнаар зохион байгуулсан болно. Үүний үр дүнд Засварт буцаасан гаалийн мэдүүлгийн тоо 2024 онд 1165 буюу 6,62% болсон өмнөх оны гүйцэтгэлээс 0,88%-аар буурсан. | | |
| Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц чадавхийг бэхжүүлэх” | | | | | | | |
| 4 | Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүй | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Удирдлагын академийн сургалтын платформоор /Цахим сургалт (thinkific.com), https://surgalt.gov.mn/ / дамжуулан төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтуудад хамрагдсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй. | 1. Авилга, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдсан байна. рагдсан байна.<br>2. Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байна. | 1. Тус газрын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх сургалтад 3 удаа хамрагдсан.<br>2. Төрийн албан хаагчийн “Ёс зүйн тухай” хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм” – тэй тухай бүр уншиж танилцан, хэрэгжилтийг ханган ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | |
| Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” | | | | | | | |
| 5 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээгээр ... дүгнэгдсэн. | ГЕГ-ын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын 2 дугаар хавсралтад заагдсан ажил арга хэмжээний хүрээнд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох тайлан, мэдээ судалгааг ГЕГ-ийн бүтцийн нэгж болон газрын удирдлагад хүргүүлэн ажиллаа. | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | |
| 6 | Авилгын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | ХАСХОМ – 2023 мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж ажилласан. | 1.ХАСХОМ – 2024 мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлнэ.<br>2.Гаалийн байгууллагын авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад өөрийн хувь нэмрийг оруулан ажиллана. | 1.ХАСХОМ – 2024 мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн.<br>2. Авилгын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах ажлын хүрээнд гадаад худалдаа эрхлэгч ААНБ-д авилга, ашиг сонирхлын мэдээллийг өгөх 110 дугаарыг таниулах, нийгэм, олон нийтэд авилгын хор хөнөөлийг сурталчилан, ГУБ нарт нөлөөллийн сургалт зохион байгуулж ажиллаа. | 2024.01.01-2024.12.31 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Ажлын байрны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдаж ажилласан. | Танхимын сургалтад хамрагдсан байна. | ДоГГ-аас нийт албан хаагчид болон ГУБ нарын дунд зохион байгуулсан танхимын 8 сургалтад хамрагдаж, цаг үеийн мэдээ, мэдээлэл, шинээр батлагдсан хууль эрх зүйн талаарх ойлголтыг авсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Удирдлагын академиас цахимаар зохион байгуулж буй “Ёс зүй, Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт” сургалтад хамрагдаж төгссөн. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамрагдсан байна. | ТАЗ-өөс зохион байгуулж буй 7:4:10 сургалтад цахимаар тогтмол хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлж ажилласан. Нийт 20 орчим сургалтад цахимаар хамрагдсан байна. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ




/Д.БАТ-ЭРДЭНЭ/

*( Албан тушаал )*

*( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ДАЛАЙБААТАРЫН БАТ-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Дорнод аймаг дахь гаалийн газар

Нэгжийн нэр: Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн алба

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”** | | | | | |
| 1. | Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 54 | 10 | 64 | |
| 2. | Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт | 54 | 10 | 64 | |
| 3. | Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 54 | 10 | 64 | |
| **Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх”** | | | | | |
| 4. | Гаалийн улсын байцаагчийн сахилга ёс зүй | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”** | | | | | |
| 5. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлэх | 54 | 10 | 64 | |
| 6. | Авилгын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | 54 | 10 | 64 | |
| **Дундаж оноо:** | | | | **65** | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Ажлын байрны сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| 2. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| **Дундаж оноо** | | | **15** | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 6 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 6 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | 7 |
| **Дундаж оноо** | | **7** | **6.6** |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6.8 |
| 2. | Багаар ажиллах | 6.8 |
| 3. | Харилцаа | 6.8 |
| **Дундаж оноо** | | **6.8** |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(65)* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15)* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(6.6)* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(6.8)* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | .... |
| **Нийт оноо** | | **93.4** |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч ............................ (П.Одсүрэн)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

..............................
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч .............................. (Д.Бат-Эрдэнэ)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

. ......................
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Хяналт, бүрдүүлэлт хорио цээрийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Л.Хишигдорж)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

............................
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч ............................ (Д.Тунгалаг)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Газрын дарга (Б.Гэрэлт-Од)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................................
*(огноо)*